



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 04 сарын 22 өдөр

Дугаар А/189

Мандалговь

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Биеийн тамир, спортын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1, 8.1.3, 8.1.7, Дундговь аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 3.4.1.2, аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.2.1.1.1 дэх заалтууд болон аймгийн Засаг даргын зөвлөлийн 2022 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн 7 дугаар хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монголын Жүдо бөхийн холбоотой хамтран зохион байгуулах Жүдо бөхийн насанд хүрэгчдийн Улсын аварга шалгаруулах Эрэгтэйчүүдийн 45 дахь удаагийн, Эмэгтэйчүүдийн 30 дахь удаагийн тэмцээний үйл ажиллагааг зохион байгуулахад хамтран ажиллах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга: Н.Түвшинжаргал (Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга)

Гишүүд:

А.Отгонбаатар	(Биеийн тамир, спортын газрын дарга)
М.Болор-Эрдэнэ	(Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн ахлах мэргэжилтэн)
Д.Доржсүрэн	(Төв халхын дуулалт жүжгийн театрын захирал)
Ц.Уранбямба	(Боловсрол, шинжлэх ухааны газрын дарга)
Б.Алтантөгс	(Эрүүл мэндийн газрын дарга)
Ю.Цолмон	(Политехник коллежийн захирал)
А.Ууганбаяр	(Тэнгэрийн тэмдэг хүүхдийн театрын захирал)
М.Батсайхан	(Нийтлэг үйлчилгээ, орон нутгийн өмчийн үйлдвэрийн газрын дарга)

Нарийн бичгийн дарга: Б.Дашбилэг (Биеийн тамир, спортын газрын даргын ахлах мэргэжилтэн)

2. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга (Н.Түвшинжаргал)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.МӨНХБАТ

4822100450